

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 3 дугаар сар 11

№ 01

Дархан Уул аймаг

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тооллогын комиссын №01, №02, №03 тоот шийдвэрүүдийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн талаархи ТУЗ-ээс гаргасан “хангалттай” гэсэн дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.
2. Компаний аудитын хорооны 2016 оны ажлын тайлан, дүгнэлтийг “хангалттай” гэж үзсүгэй.
3. Хөндлөнгийн аудитын компаниар Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Далайван аудит” ХХК-г сонгож, 1 жилийн хугацаагаар гэрээ байгуулж, хамтран ажилласугай.
4. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалтыг хэвээр нь ажиллуулах, төсөв батлах, ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийг нэгдүгээр хавсралтаар, ТУЗ-ийн хороодын дарга, гишүүдийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
5. Компаний санхүүгийн үйл ажиллагааны чадвар, эдийн засгийн хямралтай нөхцөл байдлаас хамаарч ноогдол ашиг хуваарилах боломжгүй гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Р. СҮМБЭНХҮҮ



“Дархан Нэхий” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн нэрсийн жагсаалт.

Үүнд:

- | | |
|-----------------|--------------------------|
| 1. Э. Батсайхан | 6. Х. Золжаргал |
| 2. Д. Батжаргал | Хараат бус гишүүд |
| 3. Б. Түвшин | 7. Ш. Мөнгөндуулга |
| 4. Б. Гэрэлмаа | 8. С. Мэндхүү |
| 5. Р. Сүмбэнхүү | 9. Ж. Баярсайхан |



Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийн нэрсийн жагсаалт

1. Аудитын хорооны даргаар Жадамбаагийн Баярсайхан
гишүүдэд: Банзрагчийн Түвшин
Шаравжамцийн Мөнгөндуулга
Самбуугийн Мэндхүү
2. Цалин хөлс урамшуулал, нэр дэвшүүлэх хороог нэгтгэж, хорооны даргаар Равжаагийн Сүмбэнхүү
гишүүдэд: Жадамбаагийн Баярсайхан
Шаравжамцийн Мөнгөндуулга
Самбуугийн Мэндхүү

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 3 дугаар сар 11

№ 02

Дархан Уул аймаг

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Дархан нэхий ХК –ийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 сарын 11-ны өдрийн хурлын тооллогын комиссын даргаар иргэн М. Оюунчимэг, Б. Чанцал, “БИДИСек ҮЦК” ХК-ийн төлөөлөл Э. Алтансүх нарыг тус тус томилон ажиллуулсугай.
2. Тооллогыг хуулийн хүрээнд үнэн зөв тооцоолж, холбогдох материалыг бүрдүүлж, ажиллахыг тооллогын комиссын дарга М. Оюунчимэгт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р. СҮМБЭНХҮҮ